



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсрол шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА/2023/251/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: <a href="mailto:Bat-Undraa@audit.gov.mn">Bat-Undraa@audit.gov.mn</a>
Улиастай сум	Аудитын менежер: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: <a href="mailto:boldbaatarkh@audit.gov.mn">boldbaatarkh@audit.gov.mn</a>
2024 он	Ахлах аудитор: Б.Жалбаа Утас: 89330330 Цахим хаяг: <a href="mailto:jalbaab@audit.gov.mn">jalbaab@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
81090 Уластай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ  
ГАЗРЫН ДАРГА Д.БЯМБАЦОГТ-Д

2024.05.19 № 60  
Танай \_\_\_\_\_-на № \_\_\_\_\_-т

## СӨРӨГ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Боловсрол шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Боловсрол шинжлэх ухааны газар нь батлагдсан орон тооноос илүү орон тоогоор ажилласан, алба хаагчдад үр чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг холбогдох журмын дагуу олгоогүй, цалингаас суутгасан шимтгэл, татварыг тухай бүр холбогдох байгууллагад шилжүүлээгүй, татварын өр үүсгэсэн, ажлын байрны тодорхойлолтод тусгасан ажлаа хийсэн мэргэжилтнүүдэд нэмэлт ажлын хөлс олгосон, төрийн өмч түрээслүүлсний орлогыг данс бүртгэлд тусгаагүй, шууд зарцуулсан, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг илүү, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг давхардуулан олгосон, алба хаагчдын дансаар их хэмжээний бэлэн мөнгө дамжуулсан, аймгийн Засаг даргын захирамжаар баталсан "Чадварлаг багш" хөтөлбөрийн хөрөнгийг зориулалт бус, үр ашггүй зарцуулсан, бараа материалын тооллогыг хийгээгүй, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл нь санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй, бараа материалын тайлан гаргалт, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, эмх цэгцгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.4-д "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох, 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 47.2-д "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна", Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7-д "дараах этгээдэд 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн

2024.05.19

цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох". 43.1.7.а-д "сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, сургууль, цэцэрлэгийн эмч", 43.1.7.б-д "сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн энэ хуулийн 43.1.7.а-д зааснаас бусад багш, туслах багш", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2-д "Төрийн үйлчилгээний албан хаагчид үр чадварын нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ", Засгийн газрын 2020 оны 218 дугаар тушаалаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.8-д "төрийн жинхэнэ албан хаагч төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хугацаа дуусахад 3 сараас бага хугацаа үлдсэн үед тухайн албан тушаалд томилогдсон бол түүний тус хугацаанд гүйцэтгэсэн ажлыг дараагийн үнэлгээний хугацаанд нэгтгэн дүгнэж болно", 4.14-д "нэгжийн даргаас албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн байгууллагын үнэлгээний баг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт болон байгууллагын дотоод журмыг баримтлан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар эрх бүхий этгээдэд санал гаргана", 4.14.4."D буюу сайжруулах шаардлагатай үнэлгээ авсан төрийн алба хаагчийн хувьд сургалтад хамруулах, хугацаатай үүрэг даалгавар өгөх, сануулах арга хэмжээ авах", Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 2.2-д "Энэ журмын 1.1-д заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон төрийн албан хаагчид 2.1-д зааснаар тогтоосон үндсэн цалингийн дунджийг нь төрийн албанд ажилласан нийт жилийн тоотой тэнцэх сарын тоогоор үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно. Төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн 36 сарын албан тушаалын үндсэн цалингийн дунджаас ихгүй байна", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5-д "хэрэв төлөөний өөр хүнд мөнгө олгох бол хууль заасны дагуу төлөөлөх баримт бичиг, байгууллагын дарга, ерөнхий (ахлах) нягтлан бодогч нарын гарын үсэг бүхий зөвшөөрлийг үндэслэн олгоно", 6 дугаар зүйлийн 6.2-д "төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ(ЖМС) нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс (ЖБТ) хамааран дараах хэмжээтэй байна", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 3-д "Бараа материалын үнэт зүйлийн маягтыг нөхөх заавар" гэсэн заалтууд, стандартын тохиолдсон байх, иж бүрэн байх, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсрол шинжлэх ухааны газрын барилгыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолд үндэслэн данс бүртгэлд 1,694.6 сая төгрөгөөр тусгасан байна. Энэ нь 2023 оны Төсвийн тухай хуулиар баталсан төсөвт өртгөөс 484.5 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

#### **Аудитын гол асуудал**

Боловсрол шинжлэх ухааны газрын санхүү, төсөв хариуцсан алба хаагчдын ажлын уялдаа хангалтгүй, холбогдох эрх бүхий албан тушаалтны шийдвэр гараагүй байхад тэтгэмжийг урьдчилан олгосон, тушаалын дүн олгосон тэтгэмжийн дүнгээс зөрүүтэй, төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, төсвөөс сургалтын үйл ажиллагаанд үр ашиггүй үрэлгэн хоолны зардал гаргасан нь шинж чанарын хувьд материаллаг байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, цахим мэдээллийн системд мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, зарим мэдээллийг оруулаагүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>89,576,901.98</b>	<b>89,977,923.50</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	510,278.47	300,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	151,878.47	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	58,400.00	0.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	300,000.00	300,000.00
3351	Байгууллагаас авах авлага	300,000.00	300,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	89,066,623.51	88,757,923.50
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	61,109,816.00	61,133,816.00
35110	Тусгай зориулалттай материал	61,109,816.00	61,133,816.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	27,956,807.51	27,624,107.50
35410	Бичиг хэргийн материал	647,500.00	25,000.00
35420	Аж ахуйн материал	12,208,170.00	12,624,470.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	35,000.00
35440	Түлш, шатах тослох материал	49,000.01	0.00
35460	Хүнсний материал	112,500.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	14,939,637.50	14,939,637.50
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	0.00	920,000.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	0.00	920,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>118,527,908.00</b>	<b>1,797,871,737.56</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	118,527,908.00	1,797,871,737.56
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	115,187,908.00	1,794,531,737.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	19,074,400.00	1,713,714,457.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-19,074,400.00	-30,372,000.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,840,000.00	-11,200,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	184,987,790.40	205,737,690.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-117,797,655.71	-135,824,486.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,009,609.00	44,759,609.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29,896,835.69	-32,641,865.53
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,875,000.00	-3,341,666.64
39217	Ном	0.00	100,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	3,340,000.00	3,340,000.00
39301	Програм хангамж	1,150,000.00	1,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,150,000.00	-1,150,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,340,000.00	3,340,000.00

3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>208,104,809.98</b>	<b>1,887,849,661.06</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,483,342.00</b>	<b>14,511,857.12</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,483,342.00	14,511,857.12
413	<b>Өглөг</b>	1,483,342.00	14,511,857.12
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,424,942.00	14,511,857.12
4136	<b>Бусад өглөг</b>	58,400.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	58,400.00	0.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>206,621,467.98</b>	<b>1,873,337,803.94</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	206,621,467.98	1,873,337,803.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	240,015,492.00	240,015,492.00
51101	<b>Өмч: - төрийн</b>	240,015,492.00	240,015,492.00
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-39,806,850.08	1,626,909,485.88
51210	Өмнөх үеийн үр дүн	-153,521,820.90	-39,806,850.08
51220	Тайлант үеийн үр дүн	113,714,970.82	1,666,716,335.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,412,826.06	6,412,826.06
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>208,104,809.98</b>	<b>1,887,849,661.06</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,676,133,294.50</b>	<b>6,132,061,251.57</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>214,417,842.50</b>	<b>1,941,624,347.33</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	214,417,842.50	1,941,624,347.33
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	214,359,442.50	1,941,614,347.33
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	214,359,442.50	1,941,614,347.33
120009	Бусад орлого	58,400.00	10,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,461,715,452.00</b>	<b>4,190,436,904.24</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	4,160,902,000.00	3,954,481,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,160,902,000.00	3,954,481,600.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	300,813,452.00	235,955,304.24
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	161,577,000.00	23,546,406.24
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	55,514,200.00	146,397,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	83,722,252.00	64,631,298.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	1,380,600.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,461,441,027.68</b>	<b>4,219,232,225.28</b>

21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,461,441,027.68</b>	<b>4,219,232,225.28</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	684,704,781.91	1,012,726,535.20
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	302,104,646.00	530,527,799.88
210101	Үндсэн цалин	189,169,296.00	301,830,435.66
210102	Нэмэгдэл	56,969,789.00	125,656,617.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,921,000.00	66,690,600.00
210104	Урамшуулал	28,044,561.00	24,212,577.12
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	12,137,569.21
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	36,919,594.14	78,969,471.95
210201	Тэтгэврийн даатгал	25,065,098.96	58,877,900.13
210202	Тэтгэмжийн даатгал	2,963,623.32	5,022,895.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,370,898.53	4,018,290.65
210204	Ажилгүйдлийн даатгал	592,724.79	1,004,594.90
210205	Эрүүл мэндийн даатгал	5,927,248.54	10,045,791.13
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,292,300.00	60,719,999.92
210301	Гэрэл, цахилгаан	0.00	3,079,741.92
210302	Түлш, халаалт	0.00	54,612,000.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	3,028,258.00
210304	Байрны түрээс	9,292,300.00	0.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	29,621,715.22	13,675,200.01
210401	Бичиг хэрэг	6,933,500.00	3,898,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,489,616.16	3,029,300.01
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	575,067.06	292,710.00
210404	Ном, хэвлэл	0.00	7,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,032.00	628,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,976,000.00	5,819,690.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	3,397,500.00	0.00
2105	<b>Нормативт зардал</b>	4,712,500.00	0.00
210502	Хоол, хүнс	4,712,500.00	0.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	18,078,400.00	2,369,800.00
210702	Дотоод албан томилолт	18,078,400.00	2,369,800.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,614,800.00	5,210,298.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,614,800.00	5,210,298.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	281,360,826.55	321,253,965.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,720,600.00	4,558,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	257,885,295.55	279,799,488.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,754,931.00	36,896,127.44
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,776,736,245.77	3,206,505,690.08
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,536,807,918.49	3,183,542,948.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,341,241,758.49	1,605,696,016.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,194,766,160.00	1,574,169,932.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	3,677,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	239,928,327.28	22,962,742.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	239,928,327.28	22,962,742.08
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>214,692,266.82</b>	<b>1,912,829,026.29</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	100,977,296.00	246,112,690.33
225002	Найдваргүй авлагын алдагдал	0.00	58,400.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	100,977,296.00	246,054,290.33
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-100,977,296.00	-246,112,690.33
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>113,714,970.82</b>	<b>1,666,716,335.96</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

#### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>4,461,773,852.00</b>	<b>4,190,446,904.24</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>58,400.00</b>	<b>10,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	58,400.00	10,000.00
120009	Бусад орлого	58,400.00	10,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,461,715,452.00</b>	<b>4,190,436,904.24</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	4,160,902,000.00	3,954,481,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,160,902,000.00	3,954,481,600.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	300,813,452.00	235,955,304.24
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	161,577,000.00	23,546,406.24
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	55,514,200.00	146,397,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	83,722,252.00	64,631,298.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	1,380,600.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>4,448,373,852.00</b>	<b>4,168,847,004.24</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,448,373,852.00</b>	<b>4,168,847,004.24</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>671,637,606.23</b>	<b>962,341,314.16</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	300,679,704.00	517,289,006.29
210101	Үндсэн цалин	185,331,082.00	251,168,849.66
210102	Нэмэгдэл	56,969,789.00	151,239,740.87

210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,921,000.00	66,690,600.00
210104	Урамшуулал	30,457,833.00	37,742,040.62
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	10,447,775.14
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>37,045,303.17</b>	<b>78,969,471.95</b>
210201	Тэтгэврийн даатгал	25,190,807.99	58,877,899.21
210202	Тэтгэмжийн даатгал	2,963,623.32	5,022,895.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,370,898.53	4,018,290.92
210204	Ажилгүйдлийн даатгал	592,724.79	1,004,595.22
210205	Эрүүл мэндийн даатгал	5,927,248.54	10,045,791.46
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,292,300.00</b>	<b>60,719,999.92</b>
210301	Гэрэл, цахилгаан	0.00	3,079,741.92
210302	Түлш, халаалт	0.00	54,612,000.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	3,028,258.00
210304	Байрны түрээс	9,292,300.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,015,899.06</b>	<b>13,256,400.00</b>
210401	Бичиг хэрэг	3,476,900.00	3,274,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,949,200.00	3,038,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	575,067.06	292,710.00
210404	Ном, хэвлэл	0.00	7,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,124,332.00	628,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,890,400.00	6,014,990.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>18,078,400.00</b>	<b>2,369,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	18,078,400.00	2,369,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,975,100.00</b>	<b>5,378,798.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,975,100.00	5,378,798.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>285,550,900.00</b>	<b>284,357,838.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,546,500.00	4,558,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	276,004,400.00	279,799,488.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,776,736,245.77</b>	<b>3,206,505,690.08</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,536,807,918.49</b>	<b>3,183,542,948.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,341,241,758.49	1,605,696,016.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,194,766,160.00	1,574,169,932.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	3,677,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>239,928,327.28</b>	<b>22,962,742.08</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	239,928,327.28	22,962,742.08
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>13,400,000.00</b>	<b>21,599,900.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>13,400,000.00</b>	<b>21,599,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>13,400,000.00</b>	<b>21,599,900.00</b>

2200	Дотоод эх үүсвэрээр	13,400,000.00	21,599,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,400,000.00	21,599,900.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-13,400,000.00</b>	<b>-21,599,900.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

### ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	-153,521,820.90	92,906,497.16
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	-153,521,820.90	92,906,497.16
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	113,714,970.82	113,714,970.82
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	-39,806,850.08	206,621,467.98
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	-39,806,850.08	206,621,467.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	-39,806,850.08	206,621,467.98
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,666,716,335.96	1,666,716,335.96
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	1,626,909,485.88	1,873,337,803.94

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,954,481,600.00	3,938,041,574.16
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,954,481,600.00	3,938,041,574.16
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	758,562,600.00	757,395,626.16
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	517,930,400.00	517,289,006.29
210101	Үндсэн цалин	280,275,200.00	251,168,849.66
210102	Нэмэгдэл	151,959,700.00	151,239,740.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,944,000.00	66,690,600.00
210104	Урамшуулал	53,751,500.00	37,742,040.62
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	10,447,775.14
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	78,969,500.00	78,969,471.95

210201	Тэтгэврийн даатгал	58,877,900.00	58,877,899.21
210202	Тэтгэмжийн даатгал	5,022,900.00	5,022,895.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,018,300.00	4,018,290.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,004,600.00	1,004,595.22
210205	Эрүүл мэндийн даатгал	10,045,800.00	10,045,791.46
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>60,720,000.00</b>	<b>60,719,999.92</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,760,000.00	3,079,741.92
210302	Түлш, халаалт	51,840,000.00	54,612,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,120,000.00	3,028,258.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,856,300.00</b>	<b>14,856,300.00</b>
210401	Бичиг хэрэг	2,928,700.00	3,274,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,980,300.00	3,038,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	204,000.00	292,710.00
210404	Ном, хэвлэл	127,900.00	107,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	606,400.00	628,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,009,000.00	7,514,890.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,000,000.00</b>	<b>20,000,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,372,700.00</b>	<b>2,369,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,372,700.00	2,369,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,378,800.00</b>	<b>5,378,798.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,378,800.00	5,378,798.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>58,334,900.00</b>	<b>57,812,250.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,560,300.00	4,558,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	53,774,600.00	53,253,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,195,919,000.00</b>	<b>3,180,645,948.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,195,919,000.00</b>	<b>3,180,645,948.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,619,902,200.00	1,605,696,016.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,575,232,600.00	1,574,169,932.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	784,200.00	780,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,954,481,600.00</b>	<b>3,938,041,574.16</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,954,481,600.00</b>	<b>3,938,041,574.16</b>
122005	Орон нутгийн төсвөөс	3,954,481,600.00	3,938,041,574.16

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>229442588.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>229442588.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	226545588.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	226545588.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	226,545,588.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2897000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2897000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,897,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>6512716.24</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	6,512,716.24
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	235955304.24
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	235955304.24
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	23,546,406.24
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	146,397,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,631,298.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,380,600.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Боловсрол шинжлэх ухааны газар нь Боловсрол шинжлэх ухааны газар нь Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 281 -д заасан бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 2023 онд 5 зорилтын хүрээнд 105 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж 94.44 хувьтай байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Боловсрол шинжлэх ухааны газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсрол шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсрол шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,679.7 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	510.3	300.0	-210.3
Бараа материал	89,066.6	88,757.9	-308.7
Үндсэн хөрөнгө	118,527.9	1,797,871.7	1,679,343.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>208,104.8</b>	<b>1,887,849.7</b>	<b>1,679,744.9</b>
Өр төлбөр	1,483.3	14,511.9	13,028.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	206,621.5	1,873,337.8	1,666,716.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>208,104.8</b>	<b>1,887,849.7</b>	<b>1,679,744.9</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах данснудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

- ✓ Авлага дансны үлдэгдэл буурсан нь НДШ-ийн авлагыг барагдуулсантай,
- ✓ Бараа материалын үлдэгдэл буурсан нь бараа материалын эхний үлдэгдлээс зарцуулсан,
- ✓ Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өссөн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр Боловсрол шинжлэх ухааны газрын барилгыг данс бүртгэлд тусгасан, төсвийн хөрөнгөөр 21.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан
- ✓ Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь хувь хүний орлогын албан татварын 14.5 сая төгрөгийн өр үүссэн зэрэгтэй тус тус холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, боловсрол шинжлэх ухааны бодлого гэсэн 3 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,954.5 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,954.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэл 100 хувьтай байна.

Тайланд онд 3,938.0 сая төгрөгийн зардал санхүүжүүлж, 16.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Сургуулийн өмнөх боловсрол	1,242,783.5	1,237,192.7	5,590.8	
	Ерөнхий боловсрол	1,952,351.3	1,942,673.3	9,678.0	
	Үндсэн үйл ажиллагаа	759,346.8	758,175.6	1,171.2	
	ДҮН	3,954,481.6	3,938,041.6	16,440.0	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр 236.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд:

- Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт төслийн санхүүжилт 23.5 сая төгрөг
- Чадварлаг багш хөтөлбөрийн санхүүжилт 95.0 сая төгрөг
- Excel хөтөлбөрийн санхүүжилт 25.5 сая төгрөг
- Боловсролын ерөнхий газрын санхүүжилт 38.7 сая төгрөг
- Багш нарын дунд зохион байгуулах тэмцээний санхүүжилт 20.0 сая төгрөг
- Элсэлтийн ерөнхий шалгалтад өндөр оноо авсан сурагч нарт олгох тэтгэлгийн санхүүжилт 20.0 сая төгрөг
- Орон нутгийн төсвөөс олгосон бусад санхүүжилт 11.4 сая төгрөг

- Бусад орлого 1.9 сая төгрөг тус тус байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Орон нутагт хэрэгжүүлж буй Чадварлаг багш хөтөлбөрийн хамтрагч байгууллагаар ажиллаж байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Боловсрол шинжлэх ухааны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсрол шинжлэх ухааны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/53 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлаар сонгож 1,724.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 17.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 4,219.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 42.2 сая төгрөгөөр тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй, тоног төхөөрөмж худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Боловсрол, шинжлэх ухааны газрын шилэн дансны мэдээллийг шалгахад орлогыг дутуу мэдээлсэн, бусад мэдээлэх шаардлагатай мэдээллүүдийг хугацаа хоцроосон, зарим мэдээллийг оруулаагүй байна.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчил илрээгүй

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Боловсрол, шинжлэх ухааны газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийсэн байна.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх санхүүгийн аудитаар:

- Тэтгэвэрт гарсан алба хаагчид дотоод журмаар тэтгэмж давхардуулан,
- Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн алба хаагчдын ажилласан жил, цалинг буруу тооцоолж тэтгэмжийг зөрүүтэй,
- Малчнаар тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан, тэтгэвэр тогтоолгох насанд хүрээгүй алба хаагчид тэтгэмж,
- Томилолтоор ажилласан алба хаагчдад хоол унааны мөнгө,
- Засгийн газрын тогтоолоос илүү хувь хэмжээгээр, хангалтгүй үнэлгээ авсан алба хаагчдад үр дүнгийн урамшуулал,

- Хөтөлбөрийн хүрээнд томилолтоор ажилласан алба хаагчдад томилолт олгохдоо томилолтоор ажилласан хугацааг үндэслэхгүй батлагдсан төсвийн хүрээнд,
- Томилолтын хуудасны иж бүрдэл хангалтгүй, ирсэн явсан огноо бичигдээгүй, томилолтын хуудсыг хааж бичилт хийгээгүй байхад томилолт,
- Төрийн жинхэнэ алба хаагчид цол, зэрэг дэвийн нэмэгдэл давхардуулан тус тус олгосон нийт 78.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	4,370.8	3	3,810.8	87.2
Албан шаардлага	8	74,018.8	8	74,018.8	100
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>11</b>	<b>78,389.6</b>	<b>11</b>	<b>77,829.6</b>	<b>99.3</b>

Шийдвэрийн биелэлтийг FAS системд бүртгэсэн байна. Биелэлт дутуу төлбөрийн актыг аудитын явцад бүрэн барагдуулсан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 267.6 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан байна. Үүнд:

- ✓ Төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн 21.5 сая төгрөг
- ✓ Үнэ төлбөргүй ерөнхий боловсролын сургуулиудад олгосон номын дансны бичилтийг буруу хийж санхүүгийн тайлан зөрүүтэй илэрхийлсэн 246.1 сая төгрөг байна.

Аудитаар нийт 352.4 сая сая төгрөгийн зөрчил илэрсний 32.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 300.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 19.8 сая төгрөгийн зөрчилд 3 заалт зөвлөмж хүргүүлээ.

#### 5.1 Төлбөрийн акт

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- ✓ Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Чадварлаг багш” хөтөлбөрийн хөрөнгийг зориулалт бус зарцуулж, алба хаагчдыг БНХАУ-д аялуулсан 8.0 сая төгрөг
- ✓ Төрийн үйлчилгээний алба хаагчдад эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй үр чадварын нэмэгдэл олгосон 0.2 сая төгрөгийн,
- ✓ Төрийн албанд томилогдоод 3 сар болоогүй алба хаагчид улирлын үр дүнгийн урамшуулал олгосон 0.2 сая төгрөгийн,
- ✓ Гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдсэн алба хаагчид үр дүнгийн урамшуулал олгосон, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг ханган ажиллаагүй 0.2 сая төгрөгийн,
- ✓ Аймгийн сайн малчны шагнал гардуулах үйл ажиллагаанд зориулан шатахууны зардал гаргасан 0.2 сая төгрөгийн
- ✓ Хөдөө, орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан багш, ажилтанд 5 жил тутам нэг удаа олгодог тэтгэмжийг давхардуулан олгосон 16.8 сая төгрөгийн
- ✓ Холбогдох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээс илүү дүнгээр тэтгэмж олгосон 1.6 сая төгрөгийн,
- ✓ Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг илүү тооцон олгосон 5.4 сая төгрөгийн, нийт 36.2 сая төгрөгийн зөрчил байна.

## **5.2 Албан шаардлага**

- ✓ Нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татварыг цалингаас суутган тооцоогүй, тухай бүр холбогдох байгууллагад шилжүүлээгүй, татварын өглөг үүсгэсэн 19.5 сая төгрөгийн,
- ✓ Батлагдсан орон тооноос 4-6 орон тоо илүү ажиллуулсан 41.9 сая төгрөгийн,
- ✓ Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан “Чадварлаг багш” хөтөлбөрийн хөрөнгийг зориулалт бус байгууллагын урсгал үйл ажиллагаанд зарцуулсан 4.2 сая төгрөгийн,
- ✓ Төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж худалдан авахдаа холбогдох хуулийн дагуу цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй 20.0 сая төгрөгийн,
- ✓ Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийгээгүй, программ дахь үлдэгдэл санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй 107.8 сая төгрөгийн,
- ✓ Түрээсийн орлогоор худалдан авсан тавилгыг данс бүртгэлд тусгаагүй 1.4 сая төгрөгийн,
- ✓ Боловсролын байгууллагуудын удирдлагуудыг чадавхжуулах сургалтын хүрээнд төсвөөс хоолны мөнгө төлсөн 5.5 сая төгрөгийн,
- ✓ Байгууллагын алба хаагчдад ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө ажлын хөлс олгосон 3.4 сая төгрөгийн,
- ✓ Төрийн өмч түрээслүүлсний орлогыг данс бүртгэлд тусгаагүй, төрийн сангийн дансаар дамжуулалгүй зарцуулсан 1.3 сая төгрөгийн,

- ✓ Нярав болон бусад алба хаагчдын хувийн дансаар их хэмжээний хөрөнгө дамжуулан зарцуулсан 95.0 сая төгрөгийн, нийт 300.0 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Санхүүгийн аудитаар их хэмжээний материаллаг зөрчил гаргаж “Сөрөг” дүгнэлт авсан тул дарга, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулах албан шаардлагыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Хуулийн хэрэгжилттэй холбоотой**

1.1 Илрүүлэлт: Шилэн дансны цахим мэдээллийг санд орлогыг дутуу мэдээлсэн, бусад мэдээлэх шаардлагатай мэдээллүүдийг хугацаа хоцроосон, зарим мэдээллийг оруулаагүй зөрчил байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтууд, стандартын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр мэдээлж байх

#### **2. Нягтлан бодох бүртгэлтэй, тайлагналтай холбоотой**

2.1 Илрүүлэлт: Бараа материалын тайлан гаргалт, баримтын бүрдүүлэлт хангалтгүй, эмх цэгцгүй, шаардах хуудсанд үндэслэн зарлага гаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 3-д “Бараа материалын үнэт зүйлийн маягыг нөхөх заавар” гэсэн заалтууд, стандартын иж бүрэн байх, толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын тайлан сар бүр материалын нэр төрлөөр, анхан шатны баримтад үндэслэн гаргаж, нягтлан бодох бүртгэлд тусгаж байх

#### **3. Ажлын хариуцлагатай холбоотой**

3.1 Илрүүлэлт: Тэтгэвэрт гарахад олгох, хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласны 5 жилд тутам олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохдоо холбогдох эрх бүхий албан тушаалтны шийдвэрт үндэслэдэггүй, шийдвэрийн дүнгээс зөрүүтэй, урьдчилан олгосон байна. Энэ нь алба хаагчдын ажлын уялдаа хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох эрх бүхий албан тушаалтын шийдвэрт үндэслэн нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг олгож байх

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.





Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				/мянган төгрөгөөр/	
	Телбэрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Тоног төхөөрөмж худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна	1	20,000.0			1	20,000.0		
Дүн	1	20,000.0			1	20,000.0		
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Шилэн дансны цахим мэдээллийн санд нэмэлт санхүүжилтийн дансны орлого зардал, шатахууны зардлыг өссөн үзүүлэлтээр мэдээлээгүй байна.	1	0					1	0
Дүн	1	0					1	0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>20,000.0</b>			<b>1</b>	<b>20,000.0</b>	<b>1</b>	<b>0</b>

БОЛОВСРУУЛСАН : АХЛАХ АУДИТОР

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЖАЛБАА

Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР

2024.02.23

2024.02.23

2024.02.23

